

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА  
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ховд АЗЗА ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд  
хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/02/НА/-СТА-ТӨА

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Ховд хот 2023 он	Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 70433061 Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас:70432545 Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn Аудитор: Ц.Гантулга Утас: цахим хаяг: gantulgats@audit.gov.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

2022 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГ БАТАЛГААЖУУЛАХ  
ХЯНАЛТЫН ХУУДАС

2023 оны 02 сарын 01 өдөр

дугаар № 191

Ховд хот

Санхүүгийн тайланг баталгаажуулахаар өргөн барьсан сум, байгууллагын нэр:

АУГА ТӨВГ.

**Санхүүгийн тайланг хүлээн авч, аудитыг гүйцэтгэх багт  
шилжүүлэхээр өгсөн чиглэл:**

Гүйцэтгэх аудитын багийн ахлагч:

Ц.Тамсгалант

Гүйцэтгэх аудиторын нэр:

Тайланг хүлээн авч гүйцэтгэлийн үе шатанд шилжүүлсэн хугацаа:

2023 оны 3 сарын 1 өдөр

**Хянан удирдах багаас өгсөн чиглэл:**

**Санхүүгийн тайланг Төсвийн тухай хуульд заасан цагалбарт  
хугацаанд гүйцэтгэж тайланг хүргүүлье**

(Аудитор)

Аудиторын баталгаажуулж дууссан огноо:

2023 оны ... сарын ... өдөр

ГҮЙЦЭТГЭСЭН АУДИТОР:



ХОВД АЗЗА ТӨХК

**АВТО ЗАМЫН ЗАСВАР АРЧЛАЛТЫН  
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ**

Ховд аймаг, Жаргалант сум, Бичигт баг

Утас: 70433897, 70433540

И-мэйл: khovd.azza2019@gmail.com

2023.03.01 № 20

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Г ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН Г  
АУДИТЫН ГАЗАРТ

Ховд-Азза” ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн  
тайланд аудит хийж өгнө үү.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



**Агуулга**

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан .....	2
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан .....	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	5
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	6
<b>3. Санхүүгийн тайлангийн тодруулга .....</b>	<b>7</b>
<b>3.1 Байгууллагын үйл ажилагаа .....</b>	<b>7</b>
<b>3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин .....</b>	<b>7</b>
<b>3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого.....</b>	<b>9</b>
4. Аудитын тайлан .....	12
4.1 Ерөнхий зүйл .....	12
4.2 Дотоод хяналт .....	12
4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	13
4.4 Материаллаг байдал .....	13
5.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	13
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	14
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	14
8. Аудитын илрүүлэлт .....	14

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын дээд байгууллага олон улсын стандарт
АЗЗА	Авто замын засвар арчлалт
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ББӨӨ	Борлуулсан бүтээгдэхүүний өөрийн өртөг
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
ББӨ	Бараа бүтээгдэхүүний өртөг



**ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**  
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд  
Утас: 976-70433061, Факс: 976-70433061  
E-mail: khovd@audit.gov.mn

“ХОВД -АЗЗА” ТӨХК-НИЙ ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРАЛ Н.БАТЦАГААН ТАНАА

2023.03.15 № 02/105  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Ховд-АЗЗА” ТӨХК-ний 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

“Ховд-АЗЗА” ТӨХК-ний 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Компанийн удирдлага болон ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг ТӨБЗГ томилж байгаа нь Компанийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3.4 дүгээр заалттай, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын холбогдох заалттай нийцэж байна

### Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

### Бусад асуудлын хэсэг

Компанийн гүйцэтгэх захирлын 2018 оны 12 дугаар сарын 29 өдрийн А/106 дугаар тушаалаар баталж, мөрдөж буй НБББББ-нь үйл ажиллагааны онцлогт тохирсон эсэхэд горим сорил хэрэгжүүлэхэд борлуулсан бүтээгдэхүүний өртөг,

бараа материалын тусгайлсан бодлого нь тухайн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон бүртгэлийн горим, журам байхгүй зөвхөн онолын мэдээллийг багтаасан агууламжтай байгаа тул шинэчлэн батлах шаардлагатай байна

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн хүлээх үүрэг, хариуцлага**

Компанийн удирдлага санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:



Х.БОЛДБААТАР

**2.Аудит хийсэн санхүүгийн тайлан****2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Төгрөгөөр

Үзүүлэлтийн нэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1.1.1.Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	467,266,144.90	315,226,613.83
1.1.2. Дансны авлага	79,971,857.48	111,102,942.00
1.1.3. Татвар НДШ-ийн авлага	10,595,516.33	10,728,937.69
1.1.4. Бусад авлага	9,357,940.02	17,764,422.64
1.1.6. Бараа материал	133,738,946.62	273,309,899.66
1.1.9. Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө	36,500,000.00	36,500,000.00
<b>1.1.11. Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>737,430,405.35</b>	<b>764,632,815.82</b>
1.2.1 Үндсэн хөрөнгө	1,488,942,495.04	1,316,059,240.29
1.2.2 Биет бус хөрөнгө	227,284,000.00	230,284,000.00
1.2.12 Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,716,226,495.04	1,546,343,240.29
<b>1.3 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>2,453,656,900.39</b>	<b>2,310,976,056.11</b>
2.1.1.3 Татварын өр	8,623,161.68	100,540.43
2.1.1.8 Урьдчилж орсон орлого	141,247,651.39	
<b>2.1.1.13 Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>149,870,813.07</b>	<b>100,540.43</b>
2.1.2.4 Бусад урт хугацаат өр төлбөр	385,901,585.00	385,901,585.00
2.1.2.6 Урт хугацаат өр төлбөрийн дүн	385,901,585.00	385,901,585.00
2.2 Өр төлбөрийн нийт дүн	535,772,398.07	386,002,125.43
2.3 Эздийн өмч	78,052,800.00	78,052,800.00
2.3.1 Төрийн	78,052,800.00	78,052,800.00
2.3.6 Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	81,102,698.45	77,664,398.45
2.3.8 Эздийн өмчийн бусад хэсэг	1,585,552,939.76	1,585,552,939.76
2.3.9 Хуримтлагдсан ашиг	173,176,064.11	183,703,792.47
2.3.11 Эздийн өмчийн дүн	1,917,884,502.32	1,924,973,930.68
<b>2.4 ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>2,453,656,900.39</b>	<b>2,310,976,056.11</b>

**2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан**

Төгрөгөөр

Үзүүлэлт	Өмнөх үеийн дүн	Тайлант хугацаа
<b>1. Борлуулалтын орлого(Цэвэр орлого)</b>	<b>1,174,729,715.82</b>	<b>1,622,097,210.45</b>
<b>2.Борлуулсан бүтээгдэхүүний өртөг</b>	<b>1,013,115,582.19</b>	<b>1,482,854,114.14</b>
<b>3. Нийт ашиг (алдагдал)</b>	<b>161,614,133.63</b>	<b>139,243,096.31</b>
5. Хүүгийн орлого	1,354,369.56	
8. Бусад орлого	172,692,017.27	128,406,955.81
10. Ерөнхий ба удирдлагын зардал	221,163,330.51	230,737,236.09
12. Бусад зардал	99,421,856.82	34,690,459.00
14. Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	0.00
18. Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	15,075,333.13	2,222,357.03
19. Орлогын татварын зардал	9,690,936.96	1,032,880.00
20. Ердийн үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	5,384,396.17	1,189,477.03
<b>22. Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>5,384,396.17</b>	<b>1,189,477.03</b>
24. Нийт дэлгэрэнгүй орлогын дүн	5,384,396.17	1,189,477.03
25. Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	0.00	0.00

**2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

Төгрөгөөр

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2021 оны 1 сарын 1-ний үлдэгдэл	78,052,800.00	81,102,698.45	1,585,552,939.76	167,322,034.90	1,912,030,473.11
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				5,384,396.17	5,384,396.17
6	Бусад дэлгэрэнгүй орлого				7,763,723.04	7,763,723.04
7	Зарласан ногдол ашиг				(7,294,090.00)	(7,294,090.00)
8	Дахин үнэлгээний нэмэгдэлийн хэрэгжсэн дүн					
1	2022 оны 1 сарын 1-ний үлдэгдэл	78,052,800.00	81,102,698.45	1,585,552,939.76	173,176,064.11	1,917,884,502.32
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				1,189,477.03	1,189,477.03
5	Бусад дэлгэрэнгүй орлого				8,599,951.33	8,599,951.33
7	Зарласан ногдол ашиг				(2,700,000.00)	(2,700,000.00)
8	Дахин үнэлгээний нэмэгдэлийн хэрэгжсэн дүн		(3,438,300.00)		3,438,300.00	0.00
9	2022 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	78,052,800.00	77,664,398.45	1,585,552,939.76	183,703,792.47	1,924,973,930.68

**2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

Төгрөгөөр

Үзүүлэлт	Өмнөх үеийн дүн	Тайлант хугацаа
<b>1. Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
1.1 Мөнгөн орлогын дүн	1,266,664,330.5	1,797,278,961.33
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,248,306,934.00	1,759,996,062.00
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
Бусад мөнгөн орлого	18,357,396.5	37,282,899.33
1.2 Мөнгөн зарлагын дүн	1,216,986,261.2	1,877,653,492.40
Ажиллагчдад төлсөн	265,521,678.0	310,916,800.95
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	108,746,059.0	125,506,049.00
Бараа материал худалдан авахад төлсөн	246,832,387.0	529,586,850.27
Ашиглалтын зардал төлсөн	5,904,032.8	5,800,029.80
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	244,066,507.2	512,710,479.91
Татварын байгууллагад төлсөн	134,618,629.7	140,929,720.05
Даатгалын төлбөрт төлсөн	4,243,249.0	6,275,751.00
Бусад мөнгөн зарлага	207,053,718.5	245,927,811.42
<b>1.3 Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>49,678,069.24</b>	<b>(80,374,531.07)</b>
<b>2. Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
Мөнгөн орлогын дүн	-	
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
<b>Мөнгөн зарлагын дүн</b>	<b>44,699,900.0</b>	<b>68,965,000.00</b>
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	44,699,900.0	68,965,000.00

2.20 Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(44,699,900.0)	(68,965,000.00)
<b>3.Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
Мөнгөн орлогын дүн	1,354,369.6	
Хүү ба урамшууллын орлого	1,354,369.6	
Мөнгөн зарлагын дүн	7,294,090.0	2,700,000.00
Төлсөн ногдол ашиг	7,294,090.0	2,700,000.00
<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(5,939,720.4)</b>	<b>(2,700,000.00)</b>
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(961,551.2)	(152,039,531.07)
Мөнгө, ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	468,227,696.1	467,266,144.90
Мөнгө, ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	467,266,144.9	315,226,613.83

## 2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Мянган төгрөгөөр

Д/д	Үндсэн үзүүлэлт	Хэмжих нэгж	2021 оны гүйцэтгэл	2022 он		Харьцуулалт	
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувиар (2022гүй/2022төл)	Дүнгээр (2022гүй-2022төл)
1	Нийт орлого	мян.төг	1,348,776.1	1,541,087.7	1,750,504.1	113.6	209,416.4
	Үүнээс улсын чанартай ЭЗА	мян.төг	948,649.4	1,241,718.2	1,167,227.2	94.0	(74,491.0)
	Бусад	мян.төг	400,126.7	299,369.5	583,276.9	194.8	283,907.4
2	Нийт зардал	мян.төг	1,333,700.8	1,529,624.9	1,748,281.7	114.3	218,656.8
	Үйл ажиллагааны зардалд	мян.төг	221,163.3	263,557.30	230,737.2	87.5	(32,820.1)
3	Татварын өмнөх ашиг	мян.төг	15,075.3	11,462.8	2,222.4	19.4	(9,240.4)
4	Цэвэр ашиг алдагдал	мян.төг	5,384.4	10,316.5	1,189.5	11.5	(9,127.0)
5	Төсвийн төлбөрт	мян.төг	250,266.7	286,087.4	260,614.3	91.1	(25,473.1)
	а/Орлогын татварт	мян.төг	9,690.9	1,146.3	1,032.9	90.1	(113.4)
	б/НӨАТ	мян.төг	97,557.4	114,828.1	89,668.0	78.1	(25,160.1)
	в/НДШ	мян.төг	107,202.4	125,439.8	125,506.0	100.1	66.2
	ХАОТатварт	мян.төг	31,005.8	34,737.1	39,296.8	113.1	4,559.7
	д/ Үл хөдлөх хөрөнгийн татварт	мян.төг	1,058.1	1,500.0	1,058.1	70.5	(441.9)
	е/Тээврийн хэрэгслийн татварт	мян.төг	1,129.3	1,690.5	1,873.6	110.8	183.1
ж/Бусад татварт	мян.төг	2,622.8	6,745.6	2,178.9	32.3	(4,566.7)	
6	Төрийн өмчийн ноогдол ашиг	мян.төг	7,294.1	5,652.2	2,700.0	47.8	(2,952.2)
7	Нийт авлага	мян.төг	99,925.2	128,003.5	139,596.3	109.1	11,592.8
8	Нийт өглөг	мян.төг	535,772.4	472,515.6	386,002.1	81.7	(86,513.5)
	Үүнээс богино хугацаат	мян.төг	149,870.8	86,614.0	100.5	0.1	(86,513.5)
	8.2 Урт хугацаат өр төлбөр	мян.төг	385,901.6	385,901.6	385,901.6	100.0	-
9	Борлуулалтын 1 төгрөгт ноогдох зардал	Төг	0.989	0.993	0.999	100.6	0.01
10	Хөрөнгө оруулалт	мян.төг	44,699.9	70,056.9	68,965.0	98.4	(1,091.9)

11	Ажиллагсдын тоо	хүн	34	44	34	77.3	(10.0)
12	Цалингийн сан	мян.төг	405,915.8	482,460.5	483,365.6	100.2	905.1
13	Нэг ажилтны дундаж цалин	мян.төг	946.96	873.69	964.90	110.4	91.2

### 3. Санхүүгийн тайлангийн тодруулга

#### 3.1 Байгууллагын үйл ажиллагаа

Ховд АЗЗА ТӨХК нь “Найдвартай зам хөгжилд хөтөлнө” гэсэн эрхэм зорилгоо тодорхойлон улсын чанартай зам, замын байгууламжийн засвар арчлалтын ажлыг гүйцэтгэж, замын бэлэн байдлыг хангаж ажиллах зорилт дэвшүүлэн ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэлд хүрэх оргил, эрхэм зорилго тодорхой болж цаашид үйл ажиллагаа явуулах үндсэн чиглэл тодорч, түүнд хүрэх тэмүүлэл, удирдлага хамт олны эрхэмлэх зүйлийг багтаасан байна.

Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг

- ✓ Хайрган болон хатуу хучилттай зам барих
- ✓ Хатуу болон хайрган хучилттай зам засварлах
- ✓ Төмөр бетон, ган төмөр, модон гүүр засварлах
- ✓ Үерийн хамгаалалтын далан барих
- ✓ Замын байгууламжид хамаарах талбай барих, засах эрхийн дагуу үйл ажиллагаагаа өргөтөн ажиллах гэж тодорхойлжээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд төрийн өмчийн хувьцаат кампани статустай байна. Өмчийн 100 хувийг төр эзэмшиж байна.

#### 3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Ховд АЗЗА ТӨХК нь Засгийн газрын 2005 оны 03 дугаар сарын 36 дугаар тогтоолыг үндэслэн байгуулагдсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: 5 дугаар зүйл. “хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;...” гэсэн заалттай нийцэж байна.

Төлөөлөн удирдах зөвлөл нь хуульд заасны дагуу Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, Зам тээврийн хөгжлийн яам, Хувьцаа эзэмшигчдийн төрийн төлөөллийг хэрэгжүүлэгч 6, хараат бус 3, нийт 9 гишүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулсан байна.

Компанийн удирдлага болон ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг ТӨБЗГ томилж байгаа нь Компанийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3.4 дүгээр заалттай, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын холбогдох заалттай нийцэж байна.

2022 онд ТУЗ-ийн үйл ажиллагааны зардалд нийт 25.9 сая төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 25.1 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна. Үүнд: Цалингийн зардалд 20.6 сая, эрүүл мэнд нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 2.9 сая, бусад зардалд 1.6 сая төгрөгийн зардлыг тус тус санхүүжүүлсэн байна.

Ховд АЗЗА ТӨХК -ний Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллыг 21.1 сая төгрөгөөр тогтоосон нь ТБОНӨТХ-ийн 21 дүгээр зүйлийн 12 дахь

заалт, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 3.7-д “...цалин хөлсний хэмжээг тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааны хүрээ, санхүү, эдийн засгийн байдлыг харгалзан Хувьцаа эзэмшигчдийн хурал тогтооно, цалин хөлсний хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байна” гэсэн заалтай нийцэж байна.

Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно.” гэж заасан байна. Энэ хүрээнд Өмч эзэмшлийн гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж, газрын хууль тогтоомжийг хэрэгжүүлэн эзэмшиж буй газрын төлбөрийг хугацаанд нь бүрэн төлж, зориулалтын дагуу ашиглаж, төрийн өмчит хуулийн этгээдийн газар эзэмших эрхийг бүртгэлд тусгаж тайлагнасан байна. Төрийн өмчийн талаарх бодлого шийдвэрийг хэрэгжүүлж, төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний биелэлтийн дүнгээр 98 оноо авч “Сайн” дүнтэй дүгнэгдсэн байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3. “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх;”-д заасны дагуу дотоод зохион байгуулалтын бүтцийг ТӨБЗГ, ТУЗ-с баталсан орон тоо, бүтцийн дагуу ажиллуулж, чиг үүргийн давхардалгүй, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан батлагдсан төлөвлөгөөний хүрээнд тогтоож, удирдлагын зардал дахь цалингийн санг 2.3 хувь буюу 3.3 сая төгрөгөөр, удирдлагын зардлыг нийт дүнгээр 12.5 хувиар хэмнэж, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал зэрэг зардалд хөрөнгө зарцуулаагүй байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөх Төрийн хэмнэлтийн тухай хууль шинээр батлагдаж мөрдөгдсөн байна.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ховд АЗЗА ТӨХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр дуусгавар болсон 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Компанийн гүйцэтгэх захирлын 2018 оны 12 дугаар сарын 29 өдрийн А/106 дугаар тушаалаар баталж, мөрдөж буй НБББББ-нь үйл ажиллагааны онцлогт тохирсон эсэхэд горим сорил хэрэгжүүлэхэд борлуулсан бүтээгдэхүүний өртөг, бараа материалын тусгайлсан бодлого нь тухайн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон бүртгэлийн

горим, журам байхгүй зөвхөн онолын мэдээллийг багтаасан агууламжтай байгаа тул шинэчлэн батлах шаардлагатай байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Санхүүгийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	467,266.1	315,226.6	-152,039.5
БХХО			
Авлага	99,925.3	139,596.3	39,671.0
Бараа материал	133,738.9	273,309.9	139,571.0
БЗЭБЭБХ	36,500.0	36,500.00	0
Үндсэн хөрөнгө	1,488,942.5	1,316,059.2	-172,883.3
Биет бус хөрөнгө	227,284.0	230,284.0	3,000.0
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>2,453,656.9</b>	<b>2,310,976.0</b>	<b>-142,680.9</b>
Өр төлбөрийн дүн	535,772.4	386,002.1	-149,770.3
Богино хугацаат өглөг	149,870.8	100.5	-149,770.3
Урт хугацаат өглөг	385,901.6	385,901.6	0
Эздийн өмч	1,917,884.5	1,924,973.9	7,089.4
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>2,453,656.9</b>	<b>2,310,976.0</b>	<b>-142,680.9</b>

Мөнгөн хөрөнгө дансны оны эхний үлдэгдэл 467.3 сая төгрөг байсан бол оны эцэст 315.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Үүнээс касс дахь бэлэн мөнгөний үлдэгдэл 2.8 сая, банкин дахь харилцах дансны үлдэгдэл 312.4 сая төгрөг байна.

Авлага дансны оны эхний үлдэгдэл 99.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан бол оны эцэст 139.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй болж 39.7 сая төгрөгөөр өссөн нь тухайн жил орон нутагт гүйцэтгэсэн зам засварын ажлын баталгаат хугацааны барьцаа хөрөнгийн авлага болон хариуцан ажиллаж буй улсын чанартай авто замын А0304, А-14 чиглэлийн улсын чанартай авто замуудад хийсэн цаг үеийн онцгой ажлын санхүүжилтийн авлага, бусад ажил үйлчилгээний авлагын өсөлтөөс шалтгаалсан байна.

Эцсийн үлдэгдэл дэх 139,6 сая төгрөгийн авлагын 111.2 сая төгрөг нь харилцагч байгууллага, хувь хүмүүсээс авах авлага, 10.7 сая төгрөг нь татвар, НДШ-н авлага, 17.8 сая төгрөг нь ажиллагсдаас авах авлага байна.

Авлагын үлдэгдэлд 2022 онд үүссэн 101.1 сая, 1-2 жилийн насжилттай 2.8 сая, 2-3 жилийн насжилттай 16.3 сая, 3-аас дээш жилийн насжилттай 19.4 сая, нийт 139.6 сая төгрөгийн авлага байгаагаас 57.4 сая төгрөг нь зам засварын ажлын баталгаат хугацааны барьцаа, зам засварын ажлын гүйцэтгэлийн авлага байна. Нийт авлагаас барагдах боломжгүй, эрсдэлтэй, найдваргүй авлага байхгүй ба тайлант онд данснаас хассан найдваргүй авлага байхгүй байна.

Бараа материал данс оны эхэнд 133.7 сая төгрөг байсан бол оны эцэст 273.3 сая төгрөг болж 139.6 сая төгрөгөөр өмнөх оноос өссөн үзүүлэлттэй байна. Тайлант хугацаанд өөрийн хөрөнгөөр 934.9 сая төгрөгийн бараа материал худалдан авч 795.4 сая төгрөгийн материалыг үйл ажиллагаандаа зарцуулсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэлд 273.3 сая төгрөгийн бараа материал байгаагаас зам барилгын ажилд шаардлагатай 148.7 сая төгрөгийн түүхий эд материал, 11.1 сая төгрөгийн шатах тослох материал, 36.8 сая төгрөгийн хангамжийн материал, 58.9 сая төгрөгийн сэлбэг хэрэгсэл, 14.6 сая төгрөгийн аж ахуйн болон 3.2 сая төгрөгийн бусад материалын нөөцтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны оны эхний үлдэгдэл 1,716.2 сая төгрөгийн үлдэгдэл өртөгтэй байсан ба тайлант онд өөрийн хөрөнгөөр 62.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч, 9.2 сая төгрөгөөр хөрөнгийн капиталжуулалт хийж, 21.4 сая төгрөгийн хөрөнгө акталж данс бүртгэлээс хасаж, оны эцэст үндсэн хөрөнгийн данс 1,546.3 сая төгрөгийн үлдэгдэл өртөгтэй байна.

Үндсэн хөрөнгөөс ТӨБЗГ-ын 2022 оны 25 дугаар тогтоолыг үндэслэн нийт 21.4 сая төгрөгийн өртөгтэй, 21.4 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй 11 нэр төрлийн хөрөнгийг акталж, хөрөнгийн хөдөлгөөнийг зохих журмын дагуу данс бүртгэлд тусгасан байна.

Биет бус хөрөнгө 3.0 сая төгрөгөөр өссөн нь санхүүгийн программ хангамжид шинэчлэл, сайжруулалт, өргөтгөл хийлгэсэн капиталжих зардлаас шалтгаалжээ.

Өр төлбөр дансны үлдэгдэл оны эхэнд 535.7 сая төгрөг байсан бол тайлант оны эцэст 386.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй болж 149.7 сая төгрөгөөр буурсан байна. Эцсийн үлдэгдэл дэх 386.0 сая төгрөгийн 0.1 сая төгрөг нь богино хугацаат өр төлбөр, 385.9 сая төгрөг нь урт хугацаат өр төлбөр байна. Богино хугацаат өр төлбөрийн 0.1 сая төгрөг нь татварын өр байна.

Урт хугацаат өр төлбөр 385.9 төгрөгийн өртэй байгаа нь 2009 онд тус компанид Кувейтын сангийн хөрөнгөөр нийлүүлэгдсэн 12 нэрийн машин механизм, тоног төхөөрөмжийг бусад урт хугацаат өр төлбөрөөр бүртгэн тайлагнаснаас хойш бүртгэлд өөрчлөлт ороогүй байна.

ТӨБЗГ-н 2009 оны 09 сарын 15- ны 3/1538 тоот бичгийг үндэслэн бүртгэлд тусгасан бөгөөд урт хугацаат өр төлбөрийн эргэн төлөлт хугацаандаа хийгдэхгүй байгаа нь зээлийн гэрээ, гэрээний хуваарь, шийдвэр тодорхойгүйгээс шалтгаалсан байна.

Шалгагдагч байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт зардлыг дараах байдлаар ангилж бүртгэнэ гэж заасан байна. Үүнд:

1. Борлуулсан бүтээгдэхүүний өөрийн өртөг
2. Ерөнхий ба удирдлагын зардал
3. Бусад зардал гэсэн зардлын ангиллаар хэмжилт ба үнэлгээг үндэслэн жинхэнэ гарсан хэмжээгээр төгрөгөөр хүлээн зөвшөөрч тусгахаар заасан байна.

Санхүүгийн тайланд зардал өртгийн талаарх мэдээллийг бэлтгэх зорилгын дагуу үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөг, ерөнхий ба удирдлагын зардал, бусад зардал гэж ангилсан байна.

Өмнөх онтой харьцуулахад нийт зардал 218.6 сая төгрөгөөр өссөн нь гүйцэтгэсэн зам засварын ажлын тоо хэмжээ өссөн, шатахуун, шатах, тослох материал, сэлбэг хэрэгсэл, үндсэн түүхий эд материалын үнийн өсөлтөөс шалтгаалжээ.

Үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөгт 17 зардлуудыг хамруулсан ба өртөгт хуваарилагдаагүй зардлууд байхгүй байна.

### 3.5. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Ховд АЗЗА ХК-ийн гүйцэтгэх захирал нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Ховд АЗЗА ТӨХК-ийн 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2021.12.23-ны өдрийн 671 тоот тогтоолоор 1,541.0 сая төгрөгийн нийт орлоготой, 1,529.6 сая төгрөгийн нийт зардалтай, цэвэр ашгийг 10.3 сая. төгрөг байхаар тогтоожээ. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 70.0 сая төгрөгийг төлөвлөсөн байна.

Ховд АЗЗА ТӨХК нь 2022 оны тайлангаар 1,750.5 сая төгрөгийн нийт орлоготой, 1,748.3 сая төгрөгийн нийт зардалтай 1.2 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 1,750.5 сая төгрөг болж төлөвлөснөөс 209.4 сая төгрөг буюу 13.6 хувиар өсөж биелсэн нь зам хариуцагчийн гэрээ болон улсын чанартай замын завсар арчлалтын ажил гүйцэтгэх гэрээний дагуу улсын чанартай зам, замын байгууламжид хийх засвар арчлалтын ажил гүйцэтгэхээс гадна А0304 чиглэлийн улсын чанартай замын 286,6 км-т байрлах Зэлийн усны 12 у/м т.б.гүүрний их засварын ажил, А0304, А14 чиглэлийн замуудад хийсэн онцгой ажлын гүйцэтгэл голлон нөлөөлжээ.

Орлогын хувьд авч үзвэл борлуулалтын орлого 1,622.1 сая төгрөг, бусад орлого 128.4 сая төгрөг байна. Нийт орлогын 66.7 хувийг Ховд-Булган-Улсын хил чиглэлд 117.4 км, Ховд- Говь- Алтай чиглэлд 261.4 км, Ховд- Улаангом чиглэлд 93.6 км, Ховд – Завхан чиглэлд – 158 км, Ховд – Баян Өлгий чиглэлд – 118.2 км, нийт 748.5 км улсын чанартай зам, замын байгууламжид хийсэн засвар арчлалтын ажлаар, 15.2 хувийг А0304 чиглэлийн улсын чанартай замын 286,6 км-т байрлах Зэлийн усны 12 у/м т.б.гүүрний их засварын ажлаар гүйцэтгэсэн байна. Мөн Ховд аймгийн Чандмань суманд 22.8 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий Шаврын тохойн зам засварын ажил, Ховд аймгийн төвийн 80.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий хатуу хучилттай замын нөхөөсний ажил гүйцэтгэж графикт хугацаанд ашиглалтад өгч ажилласан байна.

Нийт зардлын гүйцэтгэл 1,748.3 сая төгрөг болж, төлөвлөснөөс 218.6 сая төгрөг буюу 14.3 хувиар өссөн гүйцэтгэлтэй байна. Энэ нь гүйцэтгэсэн ажлын тоо хэмжээ болон шатах тослох материал, үйлдвэрлэлийн үндсэн түүхий эд материалын үнийн өсөлт зэргээс шалтгаалсан байна. ББӨӨ 1482.8 сая төгрөг болж, төлөвлөгөөнөөс 251.2 сая төгрөгөөр буюу 20.4 хувиар өссөн, бусад зардал 34.6 сая төгрөг болж, төлөвлөснөөс 0.1 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 1,748.3 сая төгрөгийн 84.8 хувийг ББӨ, 13.1 хувийг ерөнхий ба удирдлагын зардал, 2.1 хувийг бусад зардал эзэлсэн байна.

Тайлант хугацаанд ерөнхий ба удирдлагын зардал 230.7 сая төгрөг болж, төлөвлөснөөс 12.5 хувиар буюу 32.8 сая төгрөгөөр хэмнэж ажилласан байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 7 нэр төрлийн техник хэрэгсэл худалдан авахад өөрийн эх үүсвэрээс 68.9 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлжээ.

Тайлант онд цэвэр ашиг 1.2 сая төгрөг болж, төлөвлөснөөс 9.1 сая төгрөгөөр дутуу байгаа нь зам засварын арчлалтын гэрээний дагуу гүйцэтгэх улсын чанартай зам, замын байгууламжийн засвар, арчлалтын ажил төлөвлөсөн хэмжээнээс 74.5 сая төгрөгөөр буурсан, тайлант хугацаанд шатахууны үнэ 2022 оны 01 сарын үнээс дунджаар 32.1 хувиар өссөн, бусад бараа материалын үнийн өсөлт болон бусад зардлаас нөлөөлжээ.

ТӨБЗГ-ын 307 дугаар тогтоолын дагуу тайлант онд 2.7 сая төгрөгийн ногдол ашиг төвлөрүүлэхээс 2.7 сая төгрөгийг Сангийн яамны төрийн сангийн төсвийн орлогын ноогдол ашгийн дансанд төвлөрүүлсэн байна.

#### **4. Аудитын тайлан**

##### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Ховд АЗЗА ТӨХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх дуусгавар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг аудитор Ц. Гантулга 2023 оны 03 дугаар сарын 01-оос 03 дугаар сарын 15-ны хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 3 дугаар сарын 01-ны өдрийн 20 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

##### **4.2 Дотоод хяналт**

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тухайн онд улсын чанартай замын засвар арчлалтын ажлын явцад Зам тээврийн хөгжлийн яамны дотоод хяналт аудит албанаас хяналт үнэлгээ, мөн ТУЗ-ын аудитын хорооноос 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хэрэгжүүлэн ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

#### 4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд аудитын зорилго оршино.

Ховд АЗЗА ТӨХК-ний 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар бүртгэж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлан гэж үнэлсэн.

#### 4.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд суурь үзүүлэлтээр батлагдсан төсвийг сонгож, эрсдэлийн үнэлгээнээс хамаарч материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “бага” гэж үнэлсэн учир материаллаг байдлын түвшнийг хамгийн ихээр буюу 2 хувиар тогтоосон.

Материаллаг байдлын түвшнийг 2021 оны батлагдсан орлогын төлөвлөгөө 1,541.1 сая төгрөгөөс 2 хувиар буюу 30.8 сая төгрөгөөр тооцож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 80 хувиар буюу 24.7 сая төгрөгөөр тогтоов.

#### 4.5 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага нь ТӨБЗГ, ТУЗ-с баталсан орон тоо, бүтцийн дагуу ажиллаж, чиг үүргийн давхардалгүй, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан батлагдсан төлөвлөгөөний хүрээнд тогтоож, 3.3 сая төгрөгийн цалинтай холбоотой зардал, албан томилолттой холбоотой 3.2 сая төгрөгийн зардал, 2.6 сая.төгрөгийн шуудан холбооны зардал, 0.9 сая.төгрөгийн бичиг хэрэгтэй холбоотой зардал, 0,8 сая.төгрөгийн ТУЗ-н зардал, бусад 20.0 сая.төгрөгийн зардлын хэмнэлтийг бий болгожээ.

#### 5.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Байгууллага нь тайлант онд нийт 190 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 190 мэдээллийг хугацаандаа бүрэн мэдээлсэн байна.

#### 5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл,Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журмын заалтыг

хэрэгжүүлж [WWW.shilendans.gov.mn](http://WWW.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан нь хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

**6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Завсрын аудит хийгдээгүй ба өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн зөвлөмж, албан шаардлага, төлбөрийн акт байхгүй байна.

**7. Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц чухал асуудал үгүй болно.

**8. Аудитын илрүүлэлт**

Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, залруулагдаагүй алдаа байхгүй тул өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  Х.БОЛДБААТАР

АУДИТЫН МЕНЕЖЕР:  А.ЦЭЦЭГСҮРЭН

ТАЙЛАНГ БИЧСЭН:

АУДИТОР:

Ц.ГАНТУЛГА